

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН 2018 ОНЫ  
САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД  
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

**АГУУЛГА**

1.	Аудитын гэрчилгээ.....	2
2.	Аудитын тайлан.....	4
2.1	Оршил.....	4
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	4
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт.....	5
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	5
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	6
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	7
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.9	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	8
2.10	үл хөдлөх хөрөнгийн дахин үнэлгээний талаар.....	8
2.11	Шилэн дансны мэдээ.....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга.....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3.	Менежментийн захидал.....	10
4.	Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	13
4.1	Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	15
4.2	Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	17
4.3	Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	19
4.4	Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	21
5.	Аудитын явцад илэрсэн алдаа зөрчлийн жагсаалт.....	24

**Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АОУС	Аудитын олон улсын стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:62-26-32-30  
E-mail: info@audit.gov.mn

ФИЗИК, ТЕХНОЛОГИЙН  
ХҮРЭЭЛЭНГИЙН ЗАХИРАЛ  
П.АЛТАНЦОГ ТАНАА

2018.02.28 № 06/360  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

## Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН  
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## **2. АУДИТЫН ТАЙЛАН**

### **2.1 Оршил**

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус хүрээлэнгийн захирал П.Алтанцог Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### **2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага**

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 12 дугаар сарын 01-нээс 2019 оны 2 дугаар сарын 15-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 2 дугаар сарын 20-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, “Ниямазон аудит” ХХК-ийн аудитор Ц.Оюунгэрэл хариуцаж хэрэгжүүлэв.

Физик, технологийн хүрээлэн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Санхүүгийн аудитын газарт 2019 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 1/05 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат, шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Физик, технологийн хүрээлэнгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Физик, технологийн хүрээлэн нь Шинжлэх ухаан технологи, инновацийг хөгжүүлэх, улс орны нийгэм, эдийн засаг, оюуны хөгжлийн тулгамдсан асуудлыг орчин үеийн шинжлэх ухааны түвшинд судлан боловсруулах, шинэ мэдлэг, бүтээгдэхүүн үйлчилгээ бий болгох гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Шинжлэх ухааны академийн ерөнхийлөгчийн 2017 оны А/73 дугаар тушаалаар баталсан Физик, технологийн хүрээлэнгийн дүрмэнд үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Физик, технологийн салбарын суурь ба хавсарга судалгааны бодлого, чиглэлийг тодорхойлоход манлайлан оролцох;

Холбогдох салбарын суурь судалгаа явуулж, олон улсын, Засгийн газрын болон бусад төслүүдийг гүйцэтгэх замаар судалгаа-боловсруулалтын ажлын үр дүнг амьдрал практикт нэвтрүүлэх;

Эрдэм шинжилгээний байгууллагууд, их дээд сургуульд хийгдэж байгаа судалгаа шинжилгээний болон сургалтын ажилд оролцох залуу халааг бэлтгэх замаар хамтарч ажиллах;

Олон улс, бүс нутаг, гадаад орнуудын болон дотоодын аж ахуйн нэгж байгууллагуудтай хамтран судалгаа шинжилгээний ажил хийх, эрдэм шинжилгээний ажлын үр дүнг патентлах, үйлдвэрлэлд нэвтрүүлэх, худалдах үйл ажиллагаа явуулах;

Эрдэм шинжилгээний хурал, симпозиум, сургалт, семинар зохион байгуулах, ном бүтээл хэвлэх;

Зохих зөвшөөрлийн дагуу дангаараа болон бусад байгууллагатай хамтран туршилт-үйлдвэрлэлийн түшиц цех, нэгж байгуулах;

Эрдэм шинжилгээний ажлын үр дүнг үндэслэн төр, засгийн байгууллага, аж ахуйн нэгжид санал, зөвлөмж хүргүүлэх, үйл ажиллагааныхаа үр дүнг тогтоосон хугацаанд ШУА-ийн Тэргүүлэгчдийн газарт тайлагнах

Физик, технологийн хүрээлэнгийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Физик, технологийн хүрээлэнгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

Аудитын явцад төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг үйл ажиллагаанд хэрэгжүүлэн ажиллаж байна.

## **2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус хүрээлэнгийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Физик, технологийн хүрээлэнгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлж, мэдээллийн технологийн

мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Физик, технологийн хүрээлэн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн "Acolous" програм хангамжийг ашиглаж байна.

Физик, технологийн хүрээлэнгийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд "дунд" гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналтын ажилтангүй байна.

## **2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Физик, технологийн хүрээлэнгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 9 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 9 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонголоо.

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны нийт зардал 1,741,851.5 мянган төгрөгийн 1 хувь болох 17,418.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 6 чиглэлээр аудитын 9 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 4 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэсэн.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.



Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг ангилсан байдал  
(мянган төгрөгөөр)

№	Шийдэл	Тоо	Дүн	Тайлбар
1	Зөвлөмж өгсөн	4	98,796.8	
	Дүн	4	98,796.8	

## 2.9 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Физик, технологийн хүрээлэнгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 1,374,366.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 1,372,927.1 мянган төгрөг буюу 99,89 хувьтай байгаа нь ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардал 1,438.9 мянган төгрөгөөр хэмнэснээс шалтгаалжээ.

Тус байгууллага 2017 онд орлогын төлөвлөгөөг 2,833.6 мянган төгрөгөөр дутуу биелүүлсэн тул аудитын зөвлөмж хүргүүлсэн бөгөөд тайлант онд батлагдсан төлөвлөгөөг 100 хувь биелүүлж, 18,500.0 мянган төгрөгийн орлого олжээ.

## 2.10 ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЛААР

Засгийн газрын 2016 оны 193 дугаар тогтоол, Сангийн сайдын 2018 оны 207 дугаар тушаалын дагуу газар, барилга байгууламжийн дахин үнэлгээг санхүүгийн тайлагналын зорилгоор “Шонхор үнэлгээ аудит” ХХК-иар хийлгэж Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраар хянуулсан байна. Дахин үнэлгээний үр дүнг санхүүгийн тайланд дараахь байдлаар тусгажээ:

Баянзүрх дүүргийн 13 дугаар хороо, 14 дүгээр хороолол, Энхтайваны өргөн чөлөөний 123/5, 123/1-д байрлах нийт 8763 м.кв газрын эзэмших эрхийг 283,745.9 мянган төгрөгөөр үнэлж, бусад биет бус хөрөнгө болон Засгийн газрын хувь оролцоог нэмэгдүүлсэн;

Физик, технологийн хүрээлэнгийн байр, өргөтгөлийн барилга, нийтийн эзэмшлийн 5, инженерийн 3 байгууламжийг 3,720,017.9 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламжийн данс болон дахин үнэлгээний нэмэгдэл дансыг нэмэгдүүлсэн;

Дулааны лабораторийн барилгын үнэлгээ 57,068.4 мянган төгрөгөөр буурсныг барилга байгууламжийн данс болон дахин үнэлгээний нэмэгдэл дансыг бууруулсан;

Бүртгэлд тусгаагүй байсан өргөтгөлийн бохирын шугам болон хашааг 21,351.4 мянган төгрөгөөр үнэлж, барилга байгууламж данс болон орлогын дансыг нэмэгдүүлсэн бичилтийг тус тус хийжээ.

## **2.11 Шилэн дансны мэдээлэл**

Физик, технологийн хүрээлэн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй. Тайлант онд нийт 151 мэдээллийг шилэн дансанд оруулсан байна.

Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## **2.12 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар дотоод хяналтыг зохих ёсоор хэрэгжүүлэх, орлогын төлөвлөгөө биелүүлэх, худалдан авалтын гэрээнд хууль журам мөрдөж ажиллах 3 зөвлөмж өгсөн. Төвлөрүүлэн захирагч Шинжлэх ухааны академи нэгдсэн журмаар дотоод аудитыг зохион байгуулахаар журам бэлтгэж, боловсруулах шатандаа явж байгаатай холбоотой 1 зөвлөмж хэрэгжих шатандаа, 2 зөвлөмж нь биелсэн байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

## **2.13 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### **3. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ**

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Физик, технологийн хүрээлэнгийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### **3.1. Эд хөрөнгийн тооллогын талаар**

##### **3.1.1 Илрүүлэлт :**

2018 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг комиссын гишүүд гарын үсгээр баталгаажуулаагүй, бараа материалын дүнг тооллогын актанд тусгаагүй, тооллого хийснийг нотлох баримт хангалтгүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72 дугаар зүйлийн 72.4.1-д “тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг ... үнэн зөв, чанартай явуулж дуусгах”, 72.4.4-т “комиссын хурлаар тооллогын үр дүнг хэлэлцэж, тооллогын бүртгэлийг баталгаажуулж, холбогдох акт, материалын хамт ... тусгай жагсаалтаар шилжүүлэн өгнө”

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

##### **3.1.2. Эрсдэл:**

Эд хөрөнгийн дутагдал гарахад түүнийг нотлох баримт хангалтгүй болох эрсдэлтэй.

##### **3.1.3. Өгсөн зөвлөмж:**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг хэрэгжүүлж, тооллогыг зохих ёсоор нь хийж хэвших, баримтжуулалтыг чанартай хийх.

### **3.1.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хугацаанд нь биелүүлнэ.

## **3.2 И-баримтын талаар**

### **3.2.1 Илрүүлэлт :**

Жолоочийн тооцооны хуудсанд явсан байршил, цаг хугацаа, спидометрийн заалтыг гүйцэд бичээгүй буюу 749.2 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг нотлох анхан шатны баримт хангалтгүй, 1,050.8 мянган төгрөгийн шатахууны тооцоог хийлгүй зардалд бичсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн зөв гаргах үндэслэл болно”, 13.7-д “ анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”,

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн, нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ыг тус тус зөрчсөн байна.

### **3.2.2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэлтэй.

### **3.2.3. Өгсөн зөвлөмж:**

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Сангийн сайдын 347 дугаар тушаалыг хэрэгжүүлж ажиллах, шатахууны зарцуулалтын тооцоог зохих ёсоор хийж хэвших

### **3.2.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хугацаанд нь биелүүлэх.

## **3.3. Баримтын бүрдлийн талаар**

### **3.3.1 Илрүүлэлт :**

Тус хүрээлэн тайлант онд 191,935.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан ба 96,532.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн и-баримт аваагүй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.2-т “бараа, ажил үйлчилгээг борлуулсан тухай бүр төлбөрийн баримтыг татвар төлөгчид олгоно”,

Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар баталсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-т “төлбөрийн баримт нь бараа, ажил үйлчилгээний төлбөр тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэнтэй тус тус нийцэхгүй байна.

### **3.3.2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах эрсдэлтэй.

**3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Бараа, ажил үйлчилгээ худалдан авах бүрт нийлүүлэгчээс төлбөрийн и-баримтыг шаардан авч байх

**3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хугацаанд нь биелүүлэх.

**3.4. Татварын авлагын талаар**

**3.4.1 Илрүүлэлт :**

Санхүүгийн байдлын тайланд авлагын үлдэгдэл тусгаагүй боловч татварын тодорхойлолтоор хувь хүнээс суутгасан орлогын албан татварын болон цалин хөлс, тэдгээртэй адилтгах орлогоос суутгасан албан татварын тайлангийн төлөлтөөр 463.9 мянган төгрөгийн илүү төлөлттэй буюу авлагатай гарсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах”, 20.2.6-д “бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулах, баримтжуулах ажлыг зохион байгуулах” гэж заасантай нийцэхгүй байна.

**3.4.2. Эрсдэл:**

Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулах.

**3.3.3. Өгсөн зөвлөмж:**

Татварын байгууллагатай татварын ногдол, төлөлтийн тооцоог нийлж, баталгаажуулах.

**3.3.4. Байгууллагаас өгсөн хариу, тайлбар:**

Аудитын зөвлөмжийг хугацаанд нь биелүүлэх.

4. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

**ФИЗИК, ТЕХНОЛОГИЙН ХҮРЭЭЛЭНГИЙН  
АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>181 359 510,89</u></b>	<b><u>191 270 899,93</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	-	680 000,00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	680 000,00
<b>34</b>	<b>УРЬДЧИЛГАА</b>	11 291 370,00	-
34600	Урьдчилж гарсан зардал	11 291 370,00	-
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	170 068 140,89	190 590 899,93
<b>351</b>	<b>Түүхий эд материал</b>	158 604 678,85	165 140 651,93
35110	Тусгай зориулалттай материал	158 604 678,85	165 140 651,93
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	11 463 462,04	25 450 248,00
35410	Бичиг хэргийн материал	6 220 377,04	15 517 749,00
35420	Аж ахуйн материал	5 243 085,00	9 932 499,00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>1 094 488 761,04</u></b>	<b><u>4 922 705 129,51</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	1 094 488 761,04	4 922 705 129,51
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	1 093 639 928,75	4 638 959 189,51
39201	Барилга, байгууламж, орон сууц	1 958 599 340,00	4 212 379 176,30
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1 400 096 867,69	-1 800 000,00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	21 495 833,25	21 495 833,25
39204	Хуримтлагдсан элэгдэл	-1 074 791,64	-4 657 430,52
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	2 360 554 523,44	2 400 618 213,44
39206	Хуримтлагдсан элэгдэл	-1 891 671 372,06	-2 030 836 790,53
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	150 191 832,71	151 982 012,27
39208	Хуримтлагдсан элэгдэл	-123 304 244,11	-129 262 499,55
39213	Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	203 910,00	203 910,00
39217	Ном	18 741 764,85	18 836 764,85
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	848 832,29	283 745 940,00
39301	Програм хангамж	4 601 840,00	4 601 840,00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-3 753 007,71	-4 601 840,00
39303	Бусад биет бус хөрөнгө	-	283 745 940,00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>1 275 848 271,93</u></b>	<b><u>5 113 976 029,44</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	-	<b><u>680 000,00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	-	680 000,00
<b>413</b>	<b>Өглөг</b>	-	680 000,00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	-	680 000,00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	680 000,00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>1 275 848 271,93</u></b>	<b><u>5 113 296 029,44</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	1 275 848 271,93	5 113 296 029,44

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2 521 138 142,53	2 804 884 082,53
51101	Өмч: - төрийн	2 521 138 142,53	2 804 884 082,53
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	- 1 482 268 403,58	-1 591 516 076,84
51210	Өмнөх үеийн үр дүн		-1 482 268 403,58
51220	Тайлант үеийн үр дүн		-109 247 673,26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	236 978 532,98	3 899 928 023,75
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>1 275 848 271,93</u></b>	<b><u>5 113 976 029,44</u></b>

#### 4.1 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>1 815 965 894,00</b>	<b>1 632 603 842,86</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>32 357 394,00</b>	<b>41 641 548,86</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	32 357 394,00	41 641 548,86
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	32 357 394,00	41 641 548,86
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15 666 394,00	18 500 006,00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	16 691 000,00	23 141 542,86
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 783 608 500,00</b>	<b>1 590 962 294,00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1 485 123 500,00	1 355 866 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 485 123 500,00	1 355 866 000,00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	298 485 000,00	235 096 294,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	23 304 294,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	298 485 000,00	211 792 000,00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1 787 504 716,63</b>	<b>1 741 851 516,12</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 743 357 316,63</b>	<b>1 738 812 584,12</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	1 743 357 316,63	1 738 812 584,12
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	1 079 638 400,00	1 030 230 800,00
210101	Үндсэн цалин	1 079 638 400,00	1 030 230 800,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	119 571 247,00	121 062 574,00
210201	Тэтгэврийн даатгал	80 739 190,43	85 585 823,00
210202	Тэтгэмжийн даатгал	10 140 675,43	10 248 401,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9 238 144,52	7 332 560,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 764 021,44	1 482 825,00
210205	Эрүүл мэндийн даатгал	17 689 215,18	16 412 965,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	66 618 452,12	59 608 200,00
210301	Гэрэл, цахилгаан	34 455 017,00	27 313 000,00
210302	Түлш, халаалт	29 864 545,46	29 871 753,25
210303	Цэвэр, бохир ус	2 298 889,66	2 423 446,75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	29 392 396,88	12 727 374,04
210401	Бичиг хэрэг	12 200 857,00	2 678 598,04
210402	Тээвэр, шатахуун	1 100 000,00	1 800 000,00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 801 118,40	1 848 452,35
210404	Ном, хэвлэл	6 707 300,00	1 799 200,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 380 000,00	1 380 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6 203 121,48	3 221 123,65
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	1 375 000,00	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 375 000,00	-



Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	19 100 000,00	20 009 360,00
210604	Урсгал засвар	19 100 000,00	20 009 360,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	13 577 450,00	9 320 000,00
210701	Гадаад албан томилолт	7 654 700,00	5 300 000,00
210702	Дотоод албан томилолт	5 922 750,00	4 020 000,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	277 786 851,97	302 089 580,92
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	276 815 100,97	299 109 580,92
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1 980 000,00
210807	Газрын төлбөр	971 751,00	1 000 000,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	136 297 518,66	183 764 695,16
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6 000 000,00	1 985 400,00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	130 297 518,66	181 779 295,16
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44 147 400,00</b>	<b>3 038 932,00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	32 700 000,00	1 600 000,00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32 700 000,00	1 600 000,00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	11 447 400,00	1 438 932,00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11 447 400,00	1 438 932,00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>28 461 177,37</u></b>	<b><u>- 109 247 673,26</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>28 461 177,37</u></b>	<b><u>- 109 247 673,26</u></b>

#### 4.2 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>1 804 880 178,00</u></b>	<b><u>1 610 142 300,00</u></b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>15 846 394,00</b>	<b>19 180 006,00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	15 846 394,00	19 180 006,00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	15 846 394,00	19 180 006,00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15 846 394,00	18 500 006,00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих		680 000,00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>1 789 033 784,00</b>	<b>1 590 962 294,00</b>
<b>1310</b>	<b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>	1 485 123 500,00	1 355 866 000,00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	1 485 123 500,00	1 355 866 000,00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	298 485 000,00	235 096 294,00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	23 304 294,00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	298 485 000,00	211 792 000,00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	5 425 284,00	-
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	5 425 284,00	
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>1 680 746 578,00</u></b>	<b><u>1 569 983 610,00</u></b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1 680 746 578,00</b>	<b>1 569 983 610,00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1 636 599 178,00</b>	<b>1 566 264 678,00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>1 085 063 684,00</b>	<b>1 030 230 800,00</b>
210101	Үндсэн цалин	1 014 341 070,00	960 032 340,00
210102	Нэмэгдэл	61 655 894,00	64 340 101,00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 066 720,00	5 858 359,00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>119 571 247,00</b>	<b>121 062 574,00</b>
210201	Тэтгэврийн даатгал	80 739 190,43	85 585 823,00
210202	Тэтгэмжийн даатгал	10 140 675,43	10 248 401,00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9 238 144,52	7 332 560,00
210204	Ажилгүйдлийн даатгал	1 764 021,44	1 482 825,00
210205	Эрүүл мэндийн даатгал	17 689 215,18	16 412 965,00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>66 618 452,12</b>	<b>59 608 200,00</b>
210301	Гэрэл, цахилгаан	34 455 017,00	27 313 000,00
210302	Түлш, халаалт	29 864 545,46	29 871 753,25
210303	Цэвэр, бохир ус	2 298 889,66	2 423 446,75
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>20 595 000,00</b>	<b>16 285 000,00</b>
210401	Бичиг хэрэг	2 495 000,00	3 270 000,00
210402	Тээвэр, шатахуун	1 100 000,00	1 800 000,00

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1 801 118,40	1 848 452,35
210404	Ном, хэвлэл	6 707 300,00	1 799 200,00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 380 000,00	1 380 000,00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	7 111 581,60	6 187 347,65
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>1 200 000,00</b>	-
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1 200 000,00	-
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>20 100 000,00</b>	<b>21 747 000,00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	1 000 000,00	
210604	Урсгал засвар	19 100 000,00	21 747 000,00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>13 577 450,00</b>	<b>9 320 000,00</b>
210701	Гадаад албан томилолт	7 654 700,00	5 300 000,00
210702	Дотоод албан томилолт	5 922 750,00	4 020 000,00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>303 693 344,88</b>	<b>306 025 704,00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	302 721 593,88	303 045 704,00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	1 980 000,00
210807	Газрын төлбөр	971 751,00	1 000 000,00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>6 180 000,00</b>	<b>1 985 400,00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	180 000,00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6 000 000,00	1 985 400,00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>44 147 400,00</b>	<b>3 718 932,00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>32 700 000,00</b>	<b>1 600 000,00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	32 700 000,00	1 600 000,00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>11 447 400,00</b>	<b>2 118 932,00</b>
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	11 447 400,00	2 118 932,00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>124 133 600,00</u></b>	<b><u>40 158 690,00</u></b>
	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>4</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)</b>	-	-
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>124 133 600,00</b>	<b>40 158 690,00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>124 133 600,00</b>	<b>40 158 690,00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>124 133 600,00</b>	<b>40 158 690,00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	124 133 600,00	40 158 690,00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>- 124 133 600,00</u></b>	<b><u>- 40 158 690,00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

### 4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	<b>2016 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2 521 138 142,53</b>	<b>317 171 431,00</b>	<b>-1 590 922 478,97</b>	<b>1 247 387 094,56</b>
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	80 192 898,02	80 192 898,02
C03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2 521 138 142,53</b>	<b>317 171 431,00</b>	<b>-1 510 729 580,95</b>	<b>1 327 579 992,58</b>
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-80 192 898,02	-	-80 192 898,02
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	28 461 177,37	28 461 177,37
D01	<b>2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2 521 138 142,53</b>	<b>236 978 532,98</b>	<b>-1 482 268 403,58</b>	<b>1 275 848 271,93</b>
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>2 521 138 142,53</b>	<b>236 978 532,98</b>	<b>-1 482 268 403,58</b>	<b>1 275 848 271,93</b>
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	283 745 940,00	3 662 949 490,77		3 946 695 430,77
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	-109 247 673,26	-109 247 673,26
D09	<b>2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>2 804 884 082,53</b>	<b>3 899 928 023,75</b>	<b>-1 591 516 076,84</b>	<b>5 113 296 029,44</b>

#### 4.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2018 оны 12 дугаар сарын 31-нээр дуусвар болсон

/ төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>1 374 366 000,00</b>	<b>1 372 927 074,00</b>	<b>1 438 926,00</b>	<b>99,9%</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1 374 366 000,00	1 372 927 074,00	1 438 926,00	99,9%
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1 372 766 000,00</b>	<b>1 371 327 074,00</b>	<b>1 438 926,00</b>	<b>99,9%</b>
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1 030 230 800,00	1 030 230 800,00	-	100,0%
210101	Үндсэн цалин	949 272 000,00	960 032 340,00	-10760340,00	101,1%
210102	Нэмэгдэл	66 273 500,00	64 340 101,00	1 933 399,00	97,1%
210103	Унаа хоолны хөнгөлөлт	9 892 300,00	5 858 359,00	4 033 941,00	59,2%
210104	Урамшуулал	4 793 000,00		4 793 000,00	
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>122 501 500,00</b>	<b>121 062 574,00</b>	<b>1 438 926,00</b>	<b>98,8%</b>
210201	Тэтгэврийн даатгал	78 190 900,00	85 585 823,00	-7394923,00	109,5%
210202	Тэтгэмжийн даатгал	11 077 700,00	10 248 401,00	829 299,00	92,5%
210203	ҮОМШӨ-ний даатгал	8 862 100,00	7 332 560,00	1 529 540,00	82,7%
210204	Ажилгүйдлийн даатгал	2 215 500,00	1 482 825,00	732 675,00	66,9%
210205	Эрүүл мэндийн даатгал	22 155 300,00	16 412 965,00	5 742 335,00	74,1%
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>59 608 200,00</b>	<b>59 608 200,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
210301	Гэрэл, цахилгаан	27 313 000,00	27 313 000,00	-	100,0%
210302	Түлш, халаалт	28 995 200,00	29 871 753,25	-876553,25	103,0%
210303	Цэвэр, бохир ус	3 300 000,00	2 423 446,75	876 553,25	73,4%
210304	Байрны түрээс			-	
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>16 380 000,00</b>	<b>16 380 000,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
210401	Бичиг хэрэг	2 400 000,00	3 270 000,00	870000,00	136,3%
210402	Тээвэр, шатахуун	1 800 000,00	1 800 000,00	-	100,0%
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3 000 000,00	1 848 452,35	1 151 547,65	61,6%
210404	Ном, хэвлэл	2 800 000,00	1 894 200,00	905 800,00	67,7%
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1 380 000,00	1 380 000,00	-	100,0%
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5 000 000,00	6 187 347,65	-1187347,65	123,7%
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>40 997 000,00</b>	<b>40 997 000,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	19 250 000,00	19 250 000,00	-	100,0%

Физик, технологийн хүрээлэнгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210604	Урсгал засвар	21 747 000,00	21 747 000,00	-	100,0%
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>4 020 000,00</b>	<b>4 020 000,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
210702	Дотоод албан томилолт	4 020 000,00	4 020 000,00	-	100,0%
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>99 028 500,00</b>	<b>99 028 500,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	96 048 500,00	96 048 500,00	-	100,0%
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1 980 000,00	1 980 000,00	-	100,0%
210807	Газрын төлбөр	1 000 000,00	1 000 000,00	-	100,0%
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1 600 000,00</b>	<b>1 600 000,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>1 600 000,00</b>	<b>1 600 000,00</b>	<b>-</b>	<b>100,0%</b>
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1 600 000,00	1 600 000,00	-	100,0%
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>1 374 366 000,00</b>	<b>1 372 927 074,00</b>	<b>1 438 926,00</b>	<b>99,9%</b>
<b>1310</b>	<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>1 355 866 000,00</b>	<b>1 354 427 068,00</b>	<b>1 438 932,00</b>	<b>99,9%</b>
131001	Улсын төсвөөс санхүүжих	1 355 866 000,00	1 354 427 068,00	1 438 932,00	99,9%
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	<b>18 500 000,00</b>	<b>18 500 006,00</b>	<b>-6,00</b>	<b>100,0%</b>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18 500 000,00	18 500 006,00	-6,00	100,0%
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	<b>144</b>	<b>127</b>	<b>17</b>	<b>88,2%</b>
620001	Удирдах ажилтан	1	1		100,0%
620002	Гүйцэтгэх ажилтан	121	104	17	86,0%
620003	Үйлчлэх ажилтан	22	22	-	100,0%

**5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт**

Огноо:	Аудитын нэр:	<b>Физик технологийн хүрээлэнгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит</b>	Аудитын код:
2019.02.25			САГ-2019/41/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	<b>Физик технологийн хүрээлэн</b>		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Үйлчлүүлэгч байгууллагын талаас алдаа, зөрчилтэй асуудлыг хариуцах хүний	
				Албан тушаал	Овог нэр
А	1	2	3	4	5
1	2018 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг комиссын гишүүд гарын үсгээр баталгаажуулаагүй, бараа материалын дүнг тооллогын актанд тусгаагүй, тооллого хийснийг нотлох баримт хангалтгүй байна.		зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
2	Жолоочийн тооцооны хуудсанд явсан байршил, цаг хугацаа, спидометрийн заалтыг гүйцэд бичээгүй буюу 749.2 мянган төгрөгийн шатахууны зарцуулалтыг нотлох анхан шатны баримт хангалтгүй, 1050.8 мянган төгрөгийн шатахууны тооцоог хийлгүй зардалд бичсэн байна.	1,800.0	зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
3	Тус хүрээлэн тайлант онд 191,935.7 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээг худалдан авсан ба 96,532.9 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээнд төлбөрийн ебаримт аваагүй байна.	96,532.9	зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
4	Санхүүгийн байдлын тайланд авлагын үлдэгдэл тусгаагүй боловч татварын тодорхойлолтоор хувь хүнээс суутгасан орлогын албан татварын тайлан болон цалин хөлс болон тэдгээртэй адилтгах орлого болон шууд бус орлогоос суутгасан албан татварын тайлангийн төлөлтөөр 463.9 мянган төгрөгийн илүү төлөлттэй буюу авлагатай гарсан байна.	463.9	зөвлөмж өгөх	Нягтлан бодогч	А.Алтайсайхан
<b>Дүн</b>		<b>98,796.8</b>			

## ТЭМДЭГЛЭЛ

A series of 30 horizontal dotted lines provided for writing the summary.